
**Мэдээллийн технологи — Мэдээллийн технологийн
засаглал — Тогтолцоо болон загвар**

Агуулга	
Өмнөх үг	3
Танилцуулга	5
1 Хамрах хүрээ	6
2 Норматив эшлэл	6
3 Нэр томъёо, тодорхойлолт	6
4 Загвар ба тогтолцоо	7
4.1 МТ-ийн засаглалын загвар	7
4.1.1. Эрх барих субъектийн үүрэг, хариуцлага	7
4.1.2 Засаглалын чиг үүрэг	8
4.1.3 Менежерүүдийн үүрэг, хариуцлага	9
4.1.4 Загвар хэрэглэх боломж	9
4.2 Мэдээллийн технологийн засаглал ба удирдлагын хоорондын хамаарал	9
4.3 Мэдээллийн технологийн засаглалын тогтолцооны үндсэн элементүүд	10
5 Загварыг хэрэглэх арга зүй	12
5.1 Эрх бүхий субъектийн үүрэг	12
5.1.1 Ерөнхий	12
5.1.2 Эрх бүхий субъект ба хяналтын механизм	12
5.2 Стратегийг боловсруулах ба хяналт	13
5.2.1 Ерөнхий	13
5.2.2 Стратеги боловсруулахад эрх бүхий субъектийн үүрэг	13
5.3 Төлөөлөл	14
5.3.1 Ерөнхий зүйл	14
5.3.2. Эрх бүхий субъектээс төлөөлөл шилжүүлэх	14
5.4 Менежерүүдийн үүрэг хариуцлага	15
5.4.1 Ерөнхий зүйл	15
5.4.2 Менежерүүдийн үүрэг	15
5.5 Засаглал ба дотоод хяналт	16
5.5.1 Ерөнхий	16
5.5.2 Дотоод хяналтыг бий болгох	16
Хавсралт А_(мэдээллийн)_Мэдээллийн технологийн сайн засаглалын зарчмууд	18
Ном зүй	19

Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) ба ОУЦТК (Олон улсын цахилгаан техникийн комисс) нь дэлхий даяар стандартчиллын тусгай тогтолцоог бүрдүүлдэг. ОУСБ болон ОУЦТК-ийн гишүүн үндэсний байгууллагууд нь техникийн үйл ажиллагааны тодорхой салбарыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагаас тодорхой чиглэлийн дагуу байгуулсан техникийн хороодоор дамжуулан олон улсын стандартыг боловсруулахад оролцдог. ОУСБ болон ОУЦТК-ийн техникийн хороод сонирхсон чиглэлээр хамтран ажилладаг. ОУСБ болон ОУЦТК-тай хамтран ажилладаг төрийн болон төрийн бус бусад олон улсын байгууллагууд уг ажилд оролцдог. Мэдээллийн технологийн салбарт ОУСБ ба ОУЦТК нь хамтарсан техникийн хороо (ISO/IEC JTC 1) байгуулан ажиллаж байна.

Энэ баримт бичгийг боловсруулахад ашигласан болон цаашид дахин сайжруулж хянах журмыг ОУСБ/ОУЦТК-ийн Удирдамжийн 1-р хэсэгт тайлбарласан болно. Тухайлсан ялгаатай төрлийн баримт бичигт шаардагдах өөр өөр шалгуур үзүүлэлт шаардлагатайг тэмдэглэвэл зохино. Энэ баримт бичгийн төслийг ОУСБ/ОУЦТК Удирдамжийн 2-р хэсэгт дурдсан хянах засвар оруулах журмын дагуу боловсруулсан болно (www.iso.org/directives -ыг үзнэ үү).

Энэ баримт бичгийн зарим бүрдэл хэсэг нь патентын эрхэд хамаарч болзошгүйд анхаарал хандуулсан. ISO болон IEC нь патентын эрхийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн тодорхойлох талаар аливаа хариуцлага хүлээхгүй. Баримт бичгийг боловсруулах явцад илэрсэн аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь Танилцуулга хэсэг болон/эсвэл ОУСБ-ын хүлээн авсан патентын мэдүүлгийн жагсаалт (www.iso.org/patents) -д байна.

Баримт бичгийг боловсруулах явцад тодорхойлсон аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулга ба/эсвэл хүлээн авсан патентын мэдүүлгийн ISO жагсаалтад оруулна (www.iso.org/patents-ыг үзнэ үү).

Энэхүү баримт бичигт ашигласан аливаа худалдааны нэр нь хэрэглэгчид тохиромжтой байх зорилгоор оруулсан мэдээлэл бөгөөд мөрдүүлэх зорилгогүй.

Тохирлын үнэлгээнд хамаарах ОУСБ-ын онцлог нэр томъёо ба хэллэг болон Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаан дахь саад тотгорыг бууруулах тухай хэлэлцээрийн зарчмыг дагаж мөрдөхтэй холбоотой мэдээллийг дараах сайтаас үзнэ үү: www.iso.org/iso/foreword.html -ыг үзнэ үү.

Энэ стандартыг Олон улсын стандартчиллын байгууллага, Олон улсын цахилгаан техникийн комиссын хамтарсан техникийн хорооны Мэдээллийн технологийн үйлчилгээний менежмент ба мэдээллийн технологийн засаглалын 40-р дэд хорооноос (ISO/IEC JTC 1/SC 40) боловсруулсан.

Энэхүү хоёр дах хэвлэл нь анхны хэвлэл (ISO/IEC TR 38502:2014)-ийг хүчингүйд тооцож, орлох бөгөөд дараах өөрчлөлтүүдийг агуулсан, бага зэргийн засвар болно.

- "Хамрах хүрээ" буюу 1-р зүйл, 3.3-ын "2-р тайлбар"-т "заавал" гэсэн тохиромжгүй үгс орсон байсныг устгасан;

- "Норматив эшлэл" буюу 2-р зүйлийг нэмсэн тул дараах заалт, дэд зүйлүүдийг зохих ёсоор дугаарласан;
- "Нэр томьёо, тодорхойлолт" буюу 3-р зүйлийн эхэнд "ISO/IEC 38500:2015 стандартад орсон нэр томьёо, тодорхойлолтууд"-ын талаар нэмж тусгасан бөгөөд ISO болон IEC-ийн нэр томьёоны мэдээллийн санг лавлагаа хэлбэрээр тусгасан болно;
- "Нэр томьёо ба тодорхойлолт" 3-р зүйлд ISO/IEC 38500:2015 стандартад дурдсан бүх тодорхойлолтыг устгаж, үлдсэн тодорхойлолтыг дахин дугаарласан;
- 1-р зургийг ISO/IEC 38500:2015 стандартын 1-р зурагтай ижил болгож Гүйцэтгэл/нийцэл сум зурж шинэчилсэн бөгөөд тайлбарт тусган шинэчилсэн;
- Ном зүйд ISO/IEC 38500 стандартын лавлагаа [1] нь "Мэдээллийн технологи-Байгууллагын мэдээллийн технологийн засаглал" гэсэн одоогийн гарчгийг шинэчлэн тусгасан.

Энэ стандартыг Олон улсын цахилгаан техникийн комиссын Хөгжиж буй оронд зориулсан хөтөлбөрийн удирдагч Г.Батцэнгэл холбогдох хууль тогтоомж, стандартын нэр томьёонд нийцүүлэн орчуулж, Монгол Банкны Мэдээллийн технологийн аудитор М.Саруул хянасан.

Танилцуулга

МТ-ийн аливаа хөрөнгө оруулалтын амжилтын хэмжүүр нь шинэ төсөл эсвэл одоогийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашигласнаар бий болсон үр ашиг юм.

Мэдээллийн технологид оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж нь худалдан авсан, сайжруулсан МТ-оос шууд гардаггүй. Харин бодит үр өгөөж нь байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хангах технологийг ашигласнаар бизнесийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийн үр дүн юм. Байгууллагуудад мэдээллийн технологийн хэрэглээтэй холбоотой эрсдэлээ удирдахын зэрэгцээ хөрөнгө оруулалтаас олсон ашгийг дээд зэргээр нэмэгдүүлэх мэдээллийн технологийн стратеги, дэмжих зохицуулалт хэрэгтэй. Шаардлагатай боломжийг бий болгож чадахгүй байх, бизнес шаардлагатай үр дүнд хүрэхгүй байх, МТ-ийн улмаас байгууллагад нөлөөлж, бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, үүргээ зөрчих, зохицуулалтын шаардлагад үл нийцэх, аюулгүй байдлын доголдол, өгөгдөл алдагдах, сул зогсолт зэрэг нь эрсдэлд хамаарна.

Мэдээллийн технологийн салбарт байгууллагын хөрөнгө оруулалтад тулгарч буй бэрхшээлүүдийн нэг нь бизнесийн стратеги, тэргүүлэх чиглэл, хэрэгцээнд тулгуурлан хөрөнгө оруулалт, худалдан авалтын шийдвэрийг гаргах явдал юм. Иймд байгууллагын засаглалыг хариуцдаг хүмүүс бизнесийн стратеги, эрсдэлд өртөмтгий байдал, тэргүүлэх чиглэл, хэрэгцээг харгалзан, МТ-ийг бизнест ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад зохих хяналт, оролцоотой байх ёстой. Хүлээгдэж буй үр өгөөжийг олж авахын тулд ойлголт, хүчин чармайлт хэрэгтэй

ISO/IEC 38500[1] нь мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтийн зохистой тэнцвэрт байдал нь сайн засаглал, менежментийн шаардлага гэдгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд үүнийг байгууллагын дээд шатнаас хэрэгжүүлэх ёстой. ISO/IEC 38500 стандартын зорилго нь эрх бүхий субъект мэдээллийн технологийн хэрэглээг үнэлэх, удирдан чиглүүлэх, хянах удирдамжаар хангадаг.

Мэдээллийн технологийн салбарт “засаглал” гэсэн нэр томъёог ашиглахтай холбоотой нэлээд төөрөгдөл зах зээлд бий болоод байна. Тухайлбал, менежментийн тогтолцоо, хяналтын тогтолцоо, мэдээллийн системд засаглал гэдэг нэр томъёог буруу хэрэглэж, харин энэ нь засаглал биш, сайн засаглалыг дэмжих хэрэгсэл юм. Засаглал ба удирдлагын үүргийн талаар төөрөгдөл байнга гардаг бөгөөд энэ нь засаглалын талаарх зохих удирдамжийг боловсруулах, засаглалын туршлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болж байна.

Мэдээллийн технологийн талаарх засаглал ба менежментийн ойлголтуудын ялгааг тодруулах зорилгоор энэхүү баримт бичгийг боловсруулсан болно. Энэ нь засаглал ба менежментийн хоорондын харилцааг харуулсан загварыг гаргаж, тус бүрд холбоотой үүрэг хариуцлагыг тодорхойлсон болно.

Мэдээллийн технологи — Мэдээллийн технологийн засаглал — Тогтолцоо болон загвар

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь засаглалын механизм ба удирдлагын мөн чанар болон байгууллагын дотор тэдгээрийн харилцан хамаарлын талаар зөвлөмжөөр хангана.

Уг баримт бичгийн зорилго нь байгууллагын одоогийн болон ирээдүйн мэдээллийн технологийн ашиглалтын засаглал ба удирдлагын харилцаа, зааг ялгааг тогтооход ашиглаж болох тогтолцоо, загварын талаар мэдээлэл өгөхөд оршино.

Энэхүү баримт бичиг нь дараах оролцогчдыг мэдээллээр хангана.

- эрх бүхий субъектүүд;
- эрх бүхий субъектээс тогтоосон эрх мэдэл, хариуцлагын хүрээнд ажилладаг менежерүүд;
- бүх хэмжээ, төрлийн байгууллагын зөвлөх буюу эрх бүхий субъектийн туслах хүмүүс; болон
- Мэдээллийн технологийн удирдлага, мэдээллийн технологийн засаглалын талаар стандарт боловсруулагчид.

2 Норматив эшлэл

Энэ баримт бичигт норматив эшлэл байхгүй болно.

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичгийн зорилгод ISO/IEC 38500 стандартад заасан нэр томъёо, тодорхойлолтууд болон дараах мэдээллийг хэрэглэнэ.

ISO болон IEC нь стандартчилалд ашиглах нэр томъёоны мэдээллийн санг дараах хаягаар ажиллуулдаг.

- IEC Electropedia: <https://www.electropedia.org/> сайтаас авах боломжтой
- ISO Онлайн хайлтын платформ: <https://www.iso.org/obp> сайтаас авах боломжтой

3.1

засаглалын тогтолцоо

байгууллагын засаглалын зохицуулалтуудыг хэрэгжүүлэх стратеги, бодлого, шийдвэр гаргах бүтэц, үүрэг хариуцлага

3.2

дотоод хяналт

бизнесийн зорилгодоо хүрэх, хүсээгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх, залруулахад үндэслэлтэй баталгааг бий болгох зорилго бүхий бодлого, журам, үйл явц, зохион байгуулалтын бүтэц

3.3

менежментийн тогтолцоо

Байгууллагын бодлого, зорилтыг бий болгохын тулд харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий элементүүдийн бүрдэл ба эдгээр зорилгод хүрэх үйл явц

Тайлбар-1: Менежментийн тогтолцоо нь нэг эсвэл хэд хэдэн объектыг хамарч болно.

Тайлбар-2: Бодлого ба зорилтуудыг тодорхойлох, харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй, байгууллагын засаглалын элементүүдийн багц ба тэдгээр зорилтуудыг хангах үйл явцууд

[ЭХ СУРВАЛЖ: ISO 9000:2015, 3.5.3.]

3.4

Эрсдэлийг бууруулах эрмэлзэл

байгууллагын бууруулах буюу тодорхой төвшинд барихыг хүсэж байгаа эрсдэлийн тоо хэмжээ ба төрөл


[ЭХ СУРВАЛЖ: ISO Guide 73:2009, 3.7.1.2]

4 Загвар ба тогтолцоо

4.1 МТ-ийн засаглалын загвар

4.1.1.Эрх барих субъектийн үүрэг, хариуцлага

Эрх барих субъект нь байгууллагын засаглалын ерөнхий хариуцлагын хэсэг болох мэдээллийн технологийн өнөөгийн болон ирээдүйн ашиглалтыг байгууллагын хүрээнд хариуцаж, үүрэг хүлээнэ.



1-р зураг - Мэдээллийн технологийн засаглалын загвар

Эрх барих субъектийн эрх мэдэл, хариуцлага, үүрэг хүлээх нь түүний эрх мэдлийн эх үүсвэрээс, тухайлбал, үйл ажиллагааны хууль тогтоомжийн зохицуулалтаас хамаарна. Байгууллагын хүрээнд эрх мэдлийн зөвшөөрөгдөх түвшин, хязгаарыг ерөнхийд нь баримтжуулна. Байгууллагын хэмжээ, төрөл, тухайн байгууллагад мөрдөгдөж буй хууль эрх зүйн тогтолцооноос хамааран энэ нь байгууллагын дүрэм, түүний хэсэг эсвэл талуудын хооронд байгуулсан энгийн гэрээ байна.

Ихэнх хувьцаат компаниудын эрх барих субъект нь ТУЗ, жишээ нь захирлуудын зөвлөл байдаг. Зарим хуулийн этгээдүүд хяналтын болон гүйцэтгэх зөвлөлтэй хоёр шатлалт ТУЗ-ийн бүтцийг ашигладаг.

4.1.2 Засаглалын чиг үүрэг

ISO/IEC 38500[1] нь эрх барих субъект нь мэдээллийн технологийн хэрэглээг дараах ажлуудаар дамжуулан засаглахыг зөвлөж байна.

- Үнэлгээ хийх;
- Удирдан чиглүүлэх;
- Мониторинг хийх.

Эрх бүхий субъект ба менежерүүд нягт хамтран ажиллаж мэдээллийн технологийн хэрэглээг удирдан, чиглүүлж, мониторинг хийх үүрэг бүхий эрх бүхий субъект

бизнесийн зорилгоо биелүүлэхийн тулд МТ-ийн хэрэглээг үнэлэх, чиглүүлэх, мониторинг хийх боломжуудыг бүрдүүлдэг.

Эрх бүхий субъект нь засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зохицуулалтын үүрэг, оролцогч талуудын хууль ёсны хүлээлт, бизнесийн орчны нөлөөлөл, бизнесийн дарамт, бизнесийн хэрэгцээ зэргийг харгалзан үзнэ.

4.1.3 Менежерүүдийн үүрэг, хариуцлага

Эрх бүхий субъектээс тодорхойлсон стратеги, бодлогын хүрээнд байгууллагын зорилгод хүрэхийг менежерүүд хариуцна. Менежерүүд хариуцсан үүргийнхээ дагуу эрх барих субъектийн өмнө хариуцлага хүлээнэ.

Байгууллагууд менежментийн шатлалын дагуу үйл ажиллагаагаа явуулж болох бөгөөд ерөнхий захирал нь ерөнхий хариуцлага, байгууллагын бусад менежерүүд зохих ёсоор шууд болон шууд бус байдлаар хариуцлага хүлээнэ. Зарим байгууллагад эрх бүхий субъектийн бүрэлдэхүүнд сонгогдсон гүйцэтгэх менежерүүд байж болно.

4.1.4 Загвар хэрэглэх боломж

Энэ зүйлд тайлбарласан мэдээллийн технологийн засаглалын загварыг төлөөлөн удирдах зөвлөл гэх мэт албан ёсны эрх бүхий субъект бүрэлдэхүүнд нь байхгүй байгууллагуудын засаглалын шаардлагыг тодорхойлоход ашиглаж болно. Үүнд эрх мэдэл, үүрэг, хариуцлага нь засгийн газрын улс төрийн салбарт байдаг төрийн байгууллагууд багтаж болно. Ийм нөхцөлд засаглалын эрх мэдэл, хариуцлагыг тухайн байгууллагын нэг буюу хэд хэдэн гүйцэтгэх менежерт шууд шилжүүлж болно. Энэ нь ерөнхийдөө эрх бүхий субъектийн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх байгууллагын гүйцэтгэх захирал (эсвэл түүнтэй адилтгах) байх болно. Жижиг бизнест нэг хүн эрх бүхий субъект болон гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж болно.

4.2 Мэдээллийн технологийн засаглал ба удирдлагын хоорондын хамаарал

Загварт тусгагдсан мэдээллийн технологийн засаглал ба удирдлагын хоорондын хамааралтай гол элементүүд нь дараах байдалтай байна.

а) Эрх бүхий субъектийн үүрэг. Эрх бүхий субъектийн гишүүд нь мэдээллийн технологийн засаглалыг хариуцаж, байгууллагын хүрээнд мэдээллийн технологийн үр дүнтэй, үр ашигтай, зохистой ашиглалтыг хариуцдаг;

б) Стратеги боловсруулах, хяналт тавих. Эрх бүхий субъект нь мэдээллийн технологийн ашиглалтын талаар байгууллагын чиглэлийг тодорхойлж, шаардлагатай үр дүнд хүрэхийн тулд байгууллагын төлөв байдал, менежерүүдийн гүйцэтгэлд мониторинг хийх арга хэрэгсэл бүхий засаглалыг бүрдүүлнэ;

в) Төлөөлөл. Эрх бүхий субъектээс олгосон эрх мэдэл, үүрэг бүхий менежерүүд мэдээллийн технологийн засаглалын асуудлыг хариуцаж болно;

г) Менежерүүдийн үүрэг хариуцлага. Менежерүүд нь эрх бүхий субъектийн тодорхойлсон мэдээллийн технологийн ашиглалтын стратеги, бодлогын хүрээнд байгууллагыг стратегийн зорилгод хүргэх үүрэгтэй; болон


е) Засаглал ба дотоод хяналт. Мэдээллийн технологийн үр дүнтэй засаглал нь байгууллагын менежментийн тогтолцооны нэг хэсэг болох үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгохыг шаардана.

Эдгээр элемент бүрийг Загвар хэрэглэх заавар. 5-р зүйлд авч үзсэн болно:

4.3 Мэдээллийн технологийн засаглалын тогтолцооны үндсэн элементүүд

Байгууллагын мэдээллийн технологийн менежментийн тогтолцоо, мэдээллийн технологийн ашиглалт нь тухайн байгууллагад бий болсон засаглалын тогтолцоонд суурилсан байна.

Бодит засаглалын тогтолцоог тухайн байгууллага өөрөө тодорхойлох бөгөөд байгууллагын хэмжээ, чиг үүрэг, эрх бүхий субъектийн тогтоосон хариуцлагын хил хязгаарын талаар шийдвэрээс хамаарах боловч үндсэн элементүүд нь 2-р зурагт үзүүлсний дагуу байна. Сүүдэрлэсэн хэсэг нь холбогдох менежментийн элементүүд.



2-р зураг — Мэдээллийн технологийн засаглалын тогтолцооны үндсэн элементүүд

Мэдээллийн технологийн засаглалын тогтолцооны гол элементүүд нь дараах зүйлсийг агуулна.

а) Мэдээллийн технологийн сайн засаглалын зарчмууд. Засаглалын тогтолцоо нь ISO/IEC 38500 болон энэхүү баримт бичгийн А хавсралтад дурдсан мэдээллийн технологийн сайн засаглалын зарчимд суурилсан байна. Зарчмууд нь байгууллага мэдээллийн технологийн ашиглалтын засаглалын зохицуулалтыг хэрхэн бий болгох талаар арга зүйгээр хангана.

б) МТ-ийг ашиглах стратеги, бодлого. Эрх бүхий субъектээс тодорхойлж, менежерүүдэд мэдээлсэн мэдээллийн технологийн ашиглалтын стратеги, бодлого нь байгууллагын менежментийн тогтолцоонд засаглалыг нэвтрүүлэх үндэс суурь болж өгнө. Өөр өөр хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон заавал биелүүлэх шаардлага, эсвэл төрийн байгууллагуудад зориулсан бодлогын удирдамжид хэсэгчлэн тулгуурласан хэдий ч стратеги, бодлого нь эрх бүхий субъект, менежерүүдийн тодорхойлсон байгууллагын онцлог шаардлагуудыг тусгасан байна. ISO/IEC 38500 стандартад тодорхойлсон зан үйлийн зарчмуудыг харгалзан стратеги, бодлогыг тодорхойлж, мэдээлж, үр дүнд мониторинг хийнэ. Үүнд:

- Мэдээллийн технологи ашиглах бизнесийн зорилго;
- Тэргүүлэх чиглэл, нөөцийг байршуулах;
- Эрх мэдлийн түвшин, шийдвэр гаргах эрх болон эрх бүхий субъектэд ямар шийдвэр гаргах эрх хадгалагдаж байгаа зэрэг;
- Мэдээллийн технологийн ашиглалтын талаар хариуцлага, хил хязгаар, эрх мэдэл, онцгой зохицуулалт, тайлагнал зэрэг тохиролцсон стратеги, бодлогод үндэслэн шийдвэр гаргах механизм;
- Мэдээллийн технологийн ашиглалттай холбоотой эрсдэлийг бууруулах эрмэлзэл, хяналтын тодорхой шаардлага; болон
- Мэдээллийн технологийн ашиглалтад шаардлагатай зан үйлийг тодорхойлсон бодлого.

в) Мэдээллийн технологийн бизнес төлөвлөлт. Мэдээллийн технологийн стратегийн төлөвлөгөө нь байгууллагын бизнесийн стратегийн одоогийн болон байнгын хэрэгцээг хангах ёстой бөгөөд бизнес төлөвлөлтийн үйл явц нь мэдээллийн технологийн өнөөгийн болон ирээдүйн чадавхыг харгалзан үзнэ. Үүнд МТ-ийн ашиглалтын үр дүнд бий болсон бизнесийн шинэчлэлүүд орно. Иймд мэдээллийн технологийн бизнес төлөвлөлт нь байгууллагын мэдээллийн технологийн засаглалын тогтолцооны салшгүй хэсэг юм.

д) Эрсдэлийн менежмент. Мэдээллийн технологийн засаглалын тогтолцоо нь мэдээллийн технологийн бүхий л үйл ажиллагаа болон шийдвэр гаргахад эрсдэлийн менежментийн шилдэг туршлагыг агуулсан байх ёстой. Мэдээллийн технологийн ашиглалтын эрсдэлийн менежмент нь байгууллагын эрсдэлийн менежментийн үйл явцад тулгуурлана.

е) Хариуцлага. Үүрэг хүлээсэн хүмүүст хариуцлага тооцох механизмыг тодорхойлж, тохиролцсон байна. Үүнд байгууллагын хэмжээнд МТ-ийн стратеги, төлөвлөгөө,

бизнесийн нэгжийн гүйцэтгэлийн (гүйцэтгэл ба нийцлийн аль алиных нь) байнгын үнэлгээ зэрэг зүйлс багтаж болно.

е) Мэдээллийн технологийн менежментийн тогтолцоо. Мэдээллийн технологийн менежментийн тогтолцоонууд нь байгууллагын стратеги болон үйл ажиллагааны зорилгод хүрэхийн тулд эрх бүхий субъектээс тогтоосон стратеги, бодлогын хүрээнд ажиллана. Үүнд бизнесийн дотоод нэгжүүд, мэргэшсэн мэдээллийн технологийн нэгжүүд эсвэл гадны ханган нийлүүлэгчид болон нийтийн үйлчилгээний үйлчилгээний эрэлт, нийлүүлэлттэй холбоотой тогтолцоонууд орно. Байгууллагын зорилгод хүрэхийн тулд менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх үүрэг нь тухайн байгууллагын менежерүүдэд хамаарна.

г) Байгууллагын мэдээллийн технологийн ашиглалт. Мэдээллийн технологийн засаглалын тогтолцооны зорилго нь байгууллагын мэдээллийн технологийн ашиглалт юм. Бизнесийн хэрэгцээг хангах зорилгоор МТ-ийг ашиглах нь засаглалын тогтолцооны нэг хэсэг болох стратеги, бодлого, түүнчлэн байгууллагын мэдээллийн технологийн менежментийн тогтолцоонд хамаарна.

Засаглалын тогтолцоо нь менежерүүдэд өдөр тутам аль болох бие дааж ажиллах боломжийг олговол зохино. Засаглал нь хамтын үнэт зүйл, зорилгыг хөгжүүлэх, чиглэлийг тогтоох, өөрчлөгдөж буй орчинд зохих хариу үйлдэл үзүүлэх бие дааж ажиллах боломжийг менежерүүдэд олгохыг шаардана.

5 Загварыг хэрэглэх арга зүй

5.1 Эрх бүхий субъектийн үүрэг

5.1.1 Ерөнхий

Эрх бүхий субъектийн гишүүд нь мэдээллийн технологийн удирдлага болон байгууллагын хүрээнд мэдээллийн технологийн үр дүнтэй, ашигтай, хүлээн зөвшөөрөгдсөн ашиглалтыг хариуцна. [4.2 а)]
--

Байгууллагын засаглалын ерөнхий үүрэг хариуцлагаас нь мэдээллийн технологийг үр дүнтэй, үр ашигтай, зохих ёсоор ашиглах талаар эрх бүхий субъектийн эрх мэдэл, үүрэг, хариуцлага бий болно.

Мэдээллийн технологийн засаглал дахь эрх бүхий субъектийн гол асуудал нь эрсдэлийг удирдахын зэрэгцээ МТ-д оруулсан хөрөнгө оруулалтаас үнэ цэнийг бий болгох явдал юм.

5.1.2 Эрх бүхий субъект ба хяналтын механизм

а) Эрх бүхий субъект нь МТ-ийн бизнесийн хараат байдлын түвшинд тохирсон мэдээллийн технологийн засаглалын хяналтын механизмыг бий болговол зохино.

б) Эрх бүхий субъект нь байгууллагын бизнесийн стратегид МТ-ийн ач холбогдол, түүнчлэн МТ-ийг ашигласнаар байгууллагад учирч болзошгүй стратегийн эрсдэлийн талаар сайтар ойлголттой байвал зохино. Эрх бүхий субъектээс мэдээллийн технологид тавих анхаарал эдгээр хүчин зүйлд үндэслэсэн байна.

в) Эрх бүхий субъект нь байгууллагын мэдээллийн технологийн ашиглалтыг хянахад эрх бүхий субъектэд туслах дэд хороог байгуулж болно. Дэд хорооны хэрэгцээ шаардлага нь тухайн байгууллага дахь мэдээллийн технологийн ач холбогдол, түүний хэмжээ зэргээс шалтгаална.

г) Эрх бүхий субъект нь өөрийн гишүүд болон холбогдох засаглалын механизмууд (Аудит, Эрсдэл, Мэдээллийн технологийн хороод гэх мэт) нь мэдээллийн технологийн ашиглалт болон ирээдүйн хандлага, чиглэлийн талаар шаардлагатай мэдлэг, ойлголттой байхаас гадна үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх зохих эрх мэдэлтэй байна.

е) Эрх бүхий субъект нь МТ-ийн засаглал үр дүнтэй байгаа эсэхэд итгэлтэй байхын тулд аудит, хараат бус үнэлгээ зэрэг үйл явцыг шаардаж мэдээллийн технологийн засаглалын механизмын үр нөлөөг хянана. Тухайлбал, эрх бүхий субъект нь аудитын хүрээнд мэдээллийн технологитой холбоотой эрсдэлийн менежмент, хяналт, засаглалын үйл явцын аудитад хангалттай хамрах хүрээг бий болговол зохино.

5.2 Стратегийг боловсруулах ба хяналт

5.2.1 Ерөнхий

Эрх бүхий субъект мэдээллийн технологийн ашиглалтын талаар байгууллагын чиг хандлагыг тодорхойлж, шаардлагатай үр дүнд хүрэхийн тулд байгууллагын төлөв байдал, менежерүүдийн гүйцэтгэлийг хянах арга хэрэгсэл бүхий засаглалыг бий болгоно. [4.2 б)]

Эрх бүхий субъект нь нь стратеги боловсруулах, стратегийг хэрэгжүүлж буй менежерүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж байгууллагыг арга зүйгээр хангана. Ихэнх байгууллагад эрх бүхий субъект гүйцэтгэх менежерүүдтэй хамтран ажиллаж, тэднээс зөвлөгөө шаарддаг. Тэд хамтдаа байгууллагын одоо болон ирээдүйн ашиг тусын тулд МТ-ийг хэрхэн хамгийн сайн ашиглах талаар сайтар төсөөлөлтэй байх ёстой.

5.2.2 Стратеги боловсруулахад эрх бүхий субъектийн үүрэг

а) Эрх бүхий субъект нь мэдээллийн технологийн ашиглалтаас үнэ цэнийг бий болгохын тулд стратегийг боловсруулахад гүйцэтгэх менежерүүдтэй хамтран ажиллаж, зөвлөгөө авч тэднийг манлайллаар хангана.

б) Эрх бүхий субъект нь бизнесийн зорилгодоо хүрэх стратегийн үр дагавар болон учирч болох аливаа эрсдэлийг харгалзан мэдээллийн технологийн бизнесийн стратегийг батална.

в) Эрх бүхий субъект нь тухайн байгууллагын гадаад, дотоод орчныг тогтмол хянаж, дүн шинжилгээ хийх шаардлагатай эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд мэдээллийн технологийн стратеги болон холбогдох аливаа бодлогыг шинэчилнэ. Үүнд үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, хүлээлт, өрсөлдөөний нөхцөл байдал, түүний давуу тал, сул тал, боломжууд, шинэ технологи, зохицуулалтын шаардлага, улс төрийн өөрчлөлт, эдийн засгийн таамаглал, социологийн хүчин зүйлс орно.

д) Эрх бүхий субъект нь байгууллагын зан төлөв байдалд нийцсэн бодлого боловсруулж хангана. Ийм бодлого нь заавал дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагыг багтаасан бөгөөд бизнесийн зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлбэл зохино. Бусад нь сайн туршлагад тулгуурласан бөгөөд эрсдэлийн менежмент эсвэл үр ашиг, үр дүнг сайжруулах чиглэлээр байгууллагыг удирдан чиглүүлнэ.

е) Эрх бүхий субъект нь онцгой тохиолдолд зорилго, стратеги, бодлогыг тодорхойлж, тайлбарлах механизмтай байна.

е) Эрх бүхий субъект нь мэдээллийн технологийн бизнесийн стратегийн бүрэлдэхүүн хэсэг болгон санал болгож буй аливаа томоохон өөрчлөлтөд бизнесийн бэлэн байдлыг ойлгож, шаардлагатай өөрчлөлтийг хийх үүрэг хариуцлага, чадавхтай байна.

5.3 Төлөөлөл

5.3.1 Ерөнхий зүйл

Мэдээллийн технологийн засаглалын асуудлыг эрх бүхий субъектээс олгосон эрх мэдэл, үүрэг бүхий менежерүүд хариуцаж болно. [4.2 в)]

Эрх бүхий субъект нь байгууллагын менежерүүдтэй хамтран ажиллах замаар байгууллагын зорилгод хүрнэ. Эрх бүхий субъект тухайн байгууллагын дүрэм болон холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх мэдлээ нэг буюу хэд хэдэн менежерт шилжүүлж болно.

Мэдээллийн технологийн засаглалыг ерөнхийд нь эрх бүхий субъект болон менежерүүд хэрэгжүүлнэ. Ихэнх байгууллагад мэдээллийн технологийн ашиглалтын хариуцлагыг МТ-ийн талаар төлөөлсөн эрх мэдэлтэнд олгохоос илүүтэйгээр менежерүүд болон бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд тухайн байгууллагыг удирдах төлөөлөх эрх мэдэл бүхий этгээдэд хуваарилдаг.

Гүйцэтгэх менежерүүдэд юуг шилжүүлж болох, эрх бүхий субъект цаашид юуг хариуцах вэ гэдэгт зарчмын хувьд хязгаарлалт байхгүй. Эрх бүхий субъект нь шийдвэр гаргах зэрэг засаглал, удирдлагын асуудлуудыг шилжүүлсэн хэдий ч байгууллагын гүйцэтгэл, нийцлийн төлөө хариуцлага хүлээнэ. Үүнд мэдээллийн технологийн ашиглалтын амжилт эсвэл бүтэлгүйтлийн үр нөлөө орно.

5.3.2. Эрх бүхий субъектээс төлөөлөл шилжүүлэх

а) Эрх бүхий субъект нь мэдээллийн технологийн засаглалын асуудлыг тухайн байгууллагын менежерүүдэд шилжүүлж болно.

б) Мэдээллийн технологийн засаглалын эрх мэдлийг шилжүүлэхдээ эрх бүхий субъект удирдах байгууллага дараах зүйлийг тодорхойлно.

- Шийдвэр гаргах үүрэг, хил хязгаарыг тодорхой тодорхойлж, тохиролцсон байх;

- Зохих нөөц эрх мэдэлтэй байх; болон
- Стратеги, бодлогод нийцэж байгаа эсэх болон зорилгодоо хүрэх гүйцэтгэлд хяналт тавих ба/эсвэл үнэлгээ хийх баталгаажуулах механизмууд

в) Эрх бүхий субъект нь эрх мэдлээ шилжүүлж буй хүмүүс шаардлагатай үр чадвартай ба эрх бүхий субъект гол шийдвэрийг зохих байдлаар хянасан хэвээр байлгана.

г) Шийдвэр гаргахын тулд ямар шийдвэрийг эрх бүхий субъектэд менежерүүдээс лавлахгүйгээр шилжүүлэхийг тодорхой болгоно.

е) Эрх бүхий субъект нь МТ-ийн засаглалын эрх мэдлийг менежерүүдэд ямар хэмжээнд шилжүүлж байгааг засаглалын бодлогод тодорхой тусгасан байна. Эрх бүхий субъект мэдээллийн технологийн талаар дараах асуудалд ихэвчлэн зүйлд оролцсон хэвээр байна.

- Мэдээллийн технологийн ашиглалтын зорилго, стратеги, бодлогыг батлах;
- Мэдээллийн технологийн хэрэглээтэй холбоотой томоохон хөрөнгө оруулалтыг батлах;
- Бизнес тасал томоохон нөлөө үзүүлэх хөтөлбөр, төслүүдэд хяналт тавих; болон
- Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдалтай холбоотой эрсдэлийн менежментийн гол арга зүйг батлах.

е) Эрх бүхий субъект нь шилжүүлсэн эрх мэдлийнхээ зохистой байдлыг тогтмол хянаж байвал зохино.

5.4 Менежерүүдийн үүрэг хариуцлага

5.4.1 Ерөнхий зүйл

Менежерүүд нь эрх бүхий этгээдээс тогтоосон мэдээллийн технологийн хэрэглээний стратеги, бодлогын хүрээнд байгууллагыг стратегийн зорилгод хүргэх үүрэгтэй [4.2 d)]

Менежерүүд нь эрх бүхий субъектээс тогтоосон эсвэл зөвшилцсон мэдээллийн технологийн стратеги, бодлогод заасан хязгаарын хүрээнд тухайн байгууллага шаардлагатай үр дүнд хүрэхийг баталгаажуулах үүрэг хүлээнэ. Менежерүүд үр дүнгийн талаар эрх бүхий субъектийн өмнө үүрэг хүлээнэ. Менежерийн хариуцлага, эрх мэдэл, үүргийг эрх бүхий субъект тогтооно. Зарим зохицуулалтын хүрээнд байгууллагын үүрэг хариуцлага болон тайлагналд тодорхой шаардлага тавьж болно.

Менежерүүд нь стратеги, бодлогын хэрэгжилт ба эрх бүхий субъектээс тодорхойлсон зорилгод хүрэхэд шаардлагатай менежментийн тогтолцооны хэрэгжилт, хяналтыг хариуцна.

5.4.2 Менежерүүдийн үүрэг

а) Эрх бүхий субъектээс тодорхойлсон мэдээллийн технологийн ашиглалтын стратеги, бодлогын хүрээнд менежерүүд бизнест шаардлагатай үр дүнд хүрэх байдлыг хангана.

б) Эрх бүхий субъектээс тодорхойлсон бизнесийн зорилгод хүрэхийн тулд менежерүүд стратеги, бодлого, менежментийн тогтолцоог хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эрх бүхий субъектээс тодорхойлсон буюу тогтоосон зарчим, бодлогод суурилсан мэдээллийн технологийн бодлого, заавар, стандартыг боловсруулж, түгээх;
- Эрх бүхий субъектээс эрх мэдлийг төлөөлсөн тохиолдолд бизнесийн стратеги төлөвлөлтийн салшгүй хэсэг болох мэдээллийн технологийн стратегийг төлөвлөх
- Бизнесийн өөрчлөлтийн санаачилгыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах механизмыг бий болгох;
- Одоо байгаа бизнесийн үйл ажиллагааны мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтийг удирдах механизмыг бий болгох;
- Мэдээллийн технологийн ашиглалтад эрсдэлийн менежментийг (байгууллагын эрсдэлийн менежментийн системтэй нэгтгэсэн) хэрэгжүүлэх;
- Мэдээллийн технологитой холбоотой хөрөнгө оруулалтыг бизнесийн үнэ цэнийг бий болгоход шаардлагатай иж бүрэн үйл ажиллагааны багц болгож удирдах; болон
- Байгууллагын гүйцэтгэл, нийцэлд мониторинг хийж, үнэлж, эрх бүхий субъектэд тайлагнах.

в) Эрх бүхий субъектээс тодорхойлсон стратеги, бодлогын хүрээнд менежерүүд шийдвэр гаргана.

5.5 Засаглал ба дотоод хяналт

5.5.1 Ерөнхий

Мэдээллийн технологийн үр дүнтэй засаглал нь байгууллагын менежментийн тогтолцооны нэг хэсэг болох үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгохыг шаардана. [4.2 е)]

Мэдээллийн технологийн үр дүнтэй засаглал нь байгууллагын бизнесийн зорилгод хүрэхэд дэмжлэг үзүүлэх менежментийн тогтолцооны нэг хэсэг болох үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгоход тулгуурлана.

Менежерүүд байгууллагад учирч болох эрсдэлийг үнэлж, дотоод хяналтын зохих тогтолцоог хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Эрх бүхий субъект нь тухайн байгууллагад хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл, түүний дотор хууль тогтоомжийн шаардлагыг харгалзан дотоод хяналтын бодлогыг тодорхойлно. Эрсдэлийг үнэлэх, чиглүүлэх, мониторинг хийх явцад эрсдэлийг харгалзан үзэх шаардлагатай тул эрсдэлийн менежмент нь засаглалын загварын гол элемент юм.

5.5.2 Дотоод хяналтыг бий болгох

а) Эрх бүхий субъект нь байгууллагын хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийг харгалзан дотоод хяналтын бодлогыг тодорхойлно. Үүнд мэдээллийн технологийн ашиглалттай холбоотой эрсдэлийг бууруулах эрмэлзэл, хяналтын тусгайлсан шаардлагуудыг багтаасан байна.

б) Менежерүүд засаглал, байгууллагын хяналтын зарчим, туршлагыг шингээсэн засаглалын тогтолцооны элемент, тогтоосон дүрмийн хүрээнд ажилладаг удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

в) Дотоод хяналтад тавих тусгайлсан шаардлагууд нь бизнесийн зорилгод хүрсэн байдал, гадаад орчны зохицуулалтын шаардлагад үндэслэнэ.

г) Эрсдэлийн түвшинд тохирсон хяналтын ажиллагааг байгууллагын бизнесийн зорилгодоо хүрэх чадварт нөлөөлж болзошгүй үйл явц, төсөл бүрд хамаарах эрсдэлийг бууруулах зорилгоор төлөвлөнө.

д) Дотоод хяналтын тогтолцоо засаглалын тогтолцооноос үүдэлтэй бөгөөд дараах зүйлийг агуулна:

- Байгууллагын доторх мэдээллийн технологийн хариуцлагыг тодорхой тодорхойлсон. Үүнд үүрэг хариуцлага, хариуцлагын хил хязгаар, эрх мэдэл, үүрэг хариуцлага, тайлагнах зохицуулалтууд орно;
- Хариуцлагаа зохистой хэрэгжүүлэх боломж бүрдүүлэхийн тулд зохих мэдээллийг найдвартай дамжуулах;
- Байгууллагын бизнесийн зорилго, бодлогод хүрэхтэй холбоотой мэдээллийн технологийн эрсдэлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх эрсдэлийн эрсдэлийн менежмент болон эрсдэлийг удирдах журам байгаа эсэх; болон
- Мэдээллийн технологийн дотоод хяналтад тогтмол мониторинг хийхийн зэрэгцээ МТ-ийн үйл ажиллагааны дотоод хяналтад байнга дүн шинжилгээ хийх

Хавсралт А (мэдээллийн)

Мэдээллийн технологийн сайн засаглалын зарчмууд

ISO/IEC 38500 стандарт нь мэдээллийн технологийн сайн засаглалын зургаан зарчмыг тодорхойлсон. Зарчмууд нь дийлэнх байгууллагад хамаарна. Энэхүү хавсралтад эдгээр зарчмуудыг жагсааж, үндсэн мэдээллийг өгсөн болно. Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/IEC 38500-аас үзнэ үү.

Зарчмууд нь шийдвэр гаргахад анхаарах агуулгуудыг тусгасан. Зарчим бүрийн тодорхойлолт нь юу болох ёстойг илэрхийлдэг боловч зарчмуудыг хэрхэн, хэзээ, хэн хэрэгжүүлэхийг заагаагүй тул эдгээр нь тухайн зарчмыг хэрэгжүүлж буй байгууллагын төлөв байдлаас хамаарна. Эрх бүхий субъект эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхийг шаардана

1-р зарчим - Хариуцлага

Байгууллага доторх хувь хүмүүс болон багууд мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтийн талаар өөрсдийн үүрэг хариуцлагаа ойлгож, хүлээн зөвшөөрсөн байна. Үйлдлийн талаар хариуцлага хүлээсэн хүмүүс эдгээр үйлдлийг хийх эрхтэй.

2-р зарчим—Стратеги

Байгууллагын бизнесийн стратеги нь МТ-ийн одоогийн болон ирээдүйн чадавх, байгууллагын бизнесийн стратегийн одоогийн болон байнгын хэрэгцээг хангах мэдээллийн технологийн стратеги төлөвлөгөөг харгалзана.

3-р зарчим—Худалдан авалт

Мэдээллийн технологийн худалдан авалт нь үндэслэлтэй, байнгын дүн шинжилгээний үндсэн дээр, тодорхой, ил тод шийдвэр гаргах замаар хийгдэнэ. Богино болон урт хугацааны аль алинд нь ашиг, боломж, зардал, эрсдэлийн зохистой тэнцвэрт байдлыг хангана.

4-р зарчим—Гүйцэтгэл

МТ нь тухайн байгууллагыг дэмжих, одоогийн болон ирээдүйн бизнесийн шаардлагад нийцсэн үйлчилгээ, үйлчилгээний түвшин, үйлчилгээний чанарыг хангах зорилготой.

5-р зарчим - Нийцэл

Мэдээллийн технологи нь заавал дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна. Бодлого, үйл ажиллагааг тодорхой тодорхойлж, хэрэгжүүлж, мөрдүүлнэ.

6-р зарчим—Хүний зан төлөв

Мэдээллийн технологийн бодлого, үйл ажиллагаа, шийдвэрүүд нь хүний зан төлөв, тэр дундаа үйл явц дахь нийт хүмүүсийн одоогийн болон хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хүндэтгэнэ.

Ном зүй

- [1] ISO/IEC 38500, Мэдээллийн технологи — Байгууллагын мэдээллийн технологийн засаглал
- [2] ISO Guide 73, Эрсдэлийн менежмент — Тайлбар толь
- [3] ЭЗХАХБ-ын Компанийн засаглалын зарчим, ЭЗХАХБ, 1999, 2004 он
- [4] ISO 9000: 2015, Чанарын менежментийн тогтолцоо — Үндсэн ойлголт ба тайлбар толь